



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны ээлжит 01 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны ээлжит 01 дүгээр хуралдаан 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр болов.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2025 оны 12 дугаар сарын 24-ний 175 тоот захирамжаар Сүрэнжав овогтой Тамирыг Хорооны орон тооны бус гишүүнээр 4 жилийн хугацаагаар томилов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар /2026-01-15/ Харилцаа холбооны зохицуулах хорооны Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт болон Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, дугаар ашиглалтын хугацааг сунгах, дугаар ашиглах эрхийг хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт); Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны 17 тоот тогтоолыг хүчингүй болгох тухай (“Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай”); ХХЗХ-той холбоотой шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй маргааны явцын талаар танилцуулга; Бусад асуудал: Ажлын албанд удирдамж чиглэл өгөх тухай зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны нийт 11 (Тогтоол №01-11, 2026-01-15) тогтоолыг тус тус батлан шийдвэрлэв.

Зохицуулах хорооны 2026 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт болон Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, дугаар ашиглалтын хугацааг сунгах, дугаар ашиглах эрхийг хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт болон холбогдох ажлын хэсэг, бүтцийн газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 10 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 10 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 2 хуулийн этгээдэд 2 тусгай зөвшөөрлийг (Хангай нутгийн хүү ХХК; Саус гоби компьютерс ХХК: Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 5 хуулийн этгээдэд 5 тусгай зөвшөөрлийг (Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 3 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрлийг (“Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх” 2 тусгай зөвшөөрөл, “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” 2 тусгай зөвшөөрөл, “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” 2 тусгай зөвшөөрлийг) сэргээсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.13 дахь хэсгийг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 04 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 4 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) сэргээсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, М-Армор ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (М-Армор ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” 12100751 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Талст эрчим ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Талст эрчим ХХК: Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх” 13400059 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт болон Багануур хөгжлийн зам НҮТББ-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 07 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг (Багануур хөгжлийн зам НҮТББ-ийн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” 12800121 тоот тусгай зөвшөөрөл болон Улаанбаатар хотын Багануур дүүргийн нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” 22800131 тоот тусгай зөвшөөрлүүдийг) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 08 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээд, 1 иргэнд 4 харилцаа холбооны сүлжээний дугаарыг 2 жилийн хугацаагаар олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 09 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд олгосон (М банк ХК: 1800-2929) 1 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилээр сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.9 дэх заалт, Сонгогчдын боловсрол НҮТББ-ын хүсэлтийг тус тус үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 10

тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай дугаарын (Сонгогчдын боловсрол НҮТББ-ын “1800-2800” дугаарлалт бүхий 30010710 тоот харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглах эрхийг) хүчингүй болгож тус тус шийдвэрлэсэн.

Тус хуралдаанаар РДЗХГ, ЗУХАГ-ын Хуулийн хэлтсээс хамтран боловсруулсан тогтоол хүчингүй болгох тухай танилцуулга, холбогдох тогтоолын төслийг хэлэлцээд, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг үндэслэн 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 11 тоот “Тогтоол хүчингүй болгох тухай ” тогтоолыг баталж, Хорооны 2018 оны 17 тоот “Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай” тогтоолыг хүчингүй болгов.

Зохицуулах хорооны 2026 оны ээлжит 01 дүгээр хуралдаанд тус хорооны ЗУХАГ, Хуулийн хэлтсээс “ХХЗХ-той холбоотой шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй маргааны явцын талаар танилцуулга (2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар)”-ыг хэлэлцүүлж, хуралдаанд сонсов. Хуралдаанаас цаашид Хорооны баталсан тогтоол, шийдвэр болон байгууллагатай холбоотой ялангуяа ХХЗХ-ноос шүүхэд гаргасан болон шүүхийн гомдол, маргааны шийдвэрлэлтийн явц, гарсан шүүхийн шийдвэрийг тухай бүр гишүүдэд шуурхай мэдээлэх, цахим хаягаар танилцуулга, мэдээлэл хүргүүлж ажиллахыг ЗУХАГ-т үүрэг чиглэл болгов.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 23 дугаар хуралдаанаар Мобиком корпорац ХХК-иас ирүүлсэн 2 хүсэлтийг судлаад энэхүү асуудлаар боловсруулсан ажлын албаны, хууль эрхзүйн дүгнэлт болон татгалзах мэдэгдлийн төслийг тус тус хэлэлцэн дэмжиж, ирүүлсэн 2 хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзаж Хорооны даргын 2025 оны 01/2354, 01/2354 тоот албан бичгээр мэдэгдэл хариуг хүргүүлсэн болно. Гэвч дээрх татгалзсан үндэслэлийг үл зөвшөөрөн Мобиком корпорац ХХК-иас 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Гомдол уламжлах тухай” 1/4651 тоот болон 1/4652 тоот албан бичгээр Хорооны дарга, гишүүдийн нэр дээр ирүүлсэн ХХЗХ-ны 2026 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар бусад асуудлын хүрээнд албан гомдлыг “Харилцаа холбооны зохицуулах хорооны дэг”-ийн дагуу авч хэлэлцэв. Тус хуралдааны энэхүү асуудлаар үеэр дарга, гишүүдийн гаргасан саналыг үндэслэн “Харилцаа холбооны зохицуулах хорооны дэг”-ийн 2.8 заалтын дагуу ирүүлсэн албан гомдлыг Ажлын албанд шилжүүлэхээр тогтож, ажлын алба уг гомдлыг яаралтай, хуулийн хүрээнд судлан үзээд санал, дүгнэлтээ 30 хоногийн дотор Хорооны хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Хорооны гишүүн бөгөөд Ажлын албаны дарга А.Лувсан-Очирт үүрэг болгов.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2026-01-20